



**USAID**  
FROM THE AMERICAN PEOPLE



Economic Policy Reform and  
Competitiveness Project

# ЭЗБШӨЧ ТӨСЛИЙН САР ТУТМЫН ЦУВРАЛ

2009 оны 2-3 дугаар сар

## Санхүү, эдийн засгийн дээд сургууль, ЭЗБШӨЧ төслөөс компанийн засаглалын хөтөлбөрийг хэрэгжүүлж эхэллээ

Санхүү, эдийн засгийн дээд сургууль (СЭЗДС), Эдийн засгийн бодлогын шинэтгэл, өрсөлдөх чадвар (ЭЗБШӨЧ) төслийн хооронд компанийн засаглалын хөтөлбөрийг боловсруулах, сургагч багш нарыг нэмж бэлтгэх хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар 2008 оны 12 дугаар сарын 8-ны өдөр байгуулсан Харилцан ойлголцлын санамж бичгийн (ХОСБ) дагуу Компанийн засаглалын захирлуудын сургагч багш нарыг бэлтгэх гурван өдөр хагасын сургалтыг энэ оны 2 дугаар сарын 21-ний өдөр зохион байгуулж, 17 хүн оролцов. Энэхүү сургалт нь СЭЗДС-ийн байранд явагдсан бөгөөд энэ нь СЭЗДС-тай 2009 онд хамтарч ажиллахаар төлөвлөсөн компанийн засаглалын цуврал арга хэмжээний эхнийх нь байлаа.



Сургалтад 17 хүн оролцсоны дотор СЭЗДС, Монгол Улсын Их сургуулийн (МУИС) ахлах эрдэмтэн багш нар, Санхүүгийн зохицуулах хороо (СЗХ), Төрийн өмчийн хороо, Монголын Ажил олгогчдын холбооны ажилтнууд, Мобиком корпорацийн төлөөлөгчид байв.

Гурван өдөр хагас үргэлжилсэн эрчимтэй сургалтын хөтөлбөрт компанийн засаглалын асуудалтай холбоотой 12 модуль багтсан. Эдгээр модулийг ЭЗБШӨЧ төслийн Компанийн засаглалын зөвлөх доктор Дэмир Енэр зохиож боловсруулсан ба СЭЗДС-ийн багш нар монгол хэлнээ орчуулсан юм. ЭЗБШӨЧ төслөөс сургагч багш нарыг бэлтгэх сургалтын өмнө буюу 2 дугаар сарын 9-ний өдөр сургалтын хөтөлбөрт цаашид ашиглах зорилгоор Монгол улсын кэйс

жишээг боловсруулахад туслалцаа үзүүлэхийн тулд кэйс жишээ бичих арга техник, арга зүйн талаар сургалт семинар зохион байгуулсан байлаа.

Сургагч багш нарыг бэлтгэх хөтөлбөрийн зорилго нь компанийн засаглалын зарчим, шилдэг туршлагыг хөрөнгийн биржид бүртгэлтэй томоохон компанийн захирлууд, ТУЗ-ийн гишүүд, гүйцэтгэх захирлуудад зааж сургах монголын зааварлагч багш нарыг бэлтгэхэд оршиж байна. Сургалтын хүрээнд компанийн засаглалын олон улсын шилдэг туршлага, төлөв байдал, одоогийн чиг хандлагын талаар сургаж, Монгол улсын компанийн засаглалын хөрсөнд буулгах талаар тайлбарлав. Сургалтын материалыг Монгол улсад үйлчилж буй хууль тогтоомж, үүний дотор Компанийн тухай хууль, СЗХ-ноос 2007 онд баталсан Компанийн засаглалын кодекс зэргийг судалж бэлтгэсэн байлаа.



Сургалт өндөрлөхөд уг сургалтыг дүүргэсэн сертификатыг оролцогчид гардан авсан. Сургагч багш нар ЭЗБШӨЧ төслийн дэмжлэгтэйгээр 3 дугаар сарын 13-15-ны өдрүүдэд компанийн захирлуудад зориулсан туршилтын сургалт явуулахаар төлөвлөж байна.

## Улсын Мэргэжлийн хяналтын газартай Харилцан ойлголцлын санамж бичигт гарын үсэг зурав

Улсын Мэргэжлийн хяналтын газрын байранд 2009 оны 2 дугаар сарын 20-ны өдөр болсон богино хэмжээний ёслолын арга хэмжээний үеэр ЭЗБШӨЧ төслөөс тус газартай хамтран ажиллах Харилцан ойлголцлын санамж бичигт (ХОСБ) гарын үсэг зурлаа. Энэхүү ХОСБ-ийн хүрээнд ЭЗБШӨЧ төсөл УМХГ-т дараахь чиглэлээр туслалцаа үзүүлэх юм. Үүнд:

- УМХГ-ын шинэчилсэн вэбсайтаар дамжуулан олон нийтэд хүргэх мэдээллийн түгээлтийг сайжруулах
- Нийслэлийн Мэргэжлийн хяналтын алба (МХА)-ны мэдээллийн систем, сүлжээний аюулгүй байдлыг сайжруулж олон нийтэд хүргэх мэдээллийн вэбсайтын найдвартай ажиллагаа, цогц байдлыг хангах
- Гаалийн газрын албадын дотоод сүлжээтэй УМХГ-ын албадыг холбоход бэлтгэх туршилтын төсөл болох Замын-Үүдийн МХА-ыг Гаалийн газрын сүлжээтэй холбохын тулд Замын-Үүдийн МХА-ны мэдээллийн

Энэхүү цувралд нийтлэгдсэн санаа бодол нь АНУ-ын Олон улсын хөгжлийн агентлаг болон АНУ-ын Засгийн газрын байр суурийг заавал илэрхийлсэн байх албагүй болно.

системийг сайжруулах, дотоод сүлжээг суурилуулах, сүлжээний аюулгүй байдлыг хангах.

Дээрх зорилтуудын хүрээнд ЭЗБШӨЧ төслийн зүгээс УМХГ-т дараах тусалцааг үзүүлнэ. Үүнд:

- Улаанбаатар, Замын-Үүдийн Мэргэжлийн хяналтын албадын мэдээллийн технологийг сайжруулах төлөвлөгөө боловсруулах
- Вэбсайтыг боловсронгуй болгох үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах, хэрэгжүүлэх
- УМХГ-ын вэбсайтын мэдээллийн бүтцийг ([www.ssia.gov.mn](http://www.ssia.gov.mn)) гаргаж, хэрэглэгчдэд чиглэсэн агуулгыг төлөвлөхөд тусалцаа үзүүлэх
- УМХГ-ын ажилтнуудад вэбсайтын удирдлага, нээлттэй эхийн агуулгын удирдлагын хэрэгслийг ашиглах, вэбсайтын агуулгыг зохиох чиглэлээр сургалт явуулах
- Замын-Үүдийн МХА-ыг Гаалийн газрын ГАМАС мэдээллийн системтэй холбохын тулд тус албанд дотоод сүлжээ суурилуулах, аюулгүй байдлыг нь хангах.



ХОСБ-т УМХГ-ыг төлөөлж тус газрын дарга Ц. Шийрэвдамба, ЭЗБШӨЧ төслийг төлөөлж төслийн удирдагч Фернандо Бертоли нар гарын үсэг зурлаа.

## Захирлуудад зориулсан Компанийн засаглалын сургалт явагдлаа

Энэ 3 дугаар сарын 13-15-ны өдрүүдэд Монголын Хөрөнгийн биржид бүртгэлтэй хувьцаат компаниудын ТУЗ-ийн 15 гишүүд, банкуудын төлөөллийг оролцуулсан орчин үеийн компанийн засаглалын сэдвээр хийсэн гурван өдрийн семинарыг Санхүү, эдийн засгийн дээд сургууль (СЭЗДС) дээр явууллаа. Сургалт семинарыг ЭЗБШӨЧ төслийн Компанийн засаглалын зөвлөх доктор Дамир Енэрийн удирдлага дор 2 дугаар сарын 21-25-

ны өдрүүдэд сургагч багш нарыг бэлтгэх сургалтад оролцож сертификат авсан зааварлагч багш нар явуулсан юм.

Уг семинар нь СЭЗДС, ЭЗБШӨЧ төслийн хооронд 2008 оны 12 дугаар сарын 16-ны өдөр гарын үсэг зурсан Харилцан ойлголцлын санамж бичгийн (ХОСБ) дагуу явуулах цуврал курс сургалтын эхнийх нь байв. ХОСБ-ийн дагуу эхний ээлжинд хийж гүйцэтгэх ажлуудад дараахь орж байна. Үүнд:

- ТУЗ-ийн гишүүдэд зориулж компанийн засаглалын 12 модулийг боловсруулж, монгол хэлнээ орчуулах
- Монголын кэйс жишээг боловсруулахад туслахын тулд кэйс жишээ бичих арга техник, арга зүйг зааж сургах хагас өдрийн сургалт
- 2 дугаар сарын 21-24-ний өдрүүдэд сургагч багш нарт зориулж явуулсан компанийн засаглалын модулийн талаархи гурван өдөр хагасын сургалт.



Компаниудын ТУЗ-ийн гишүүд, гүйцэтгэх захирлууд нь сертификат авсан зааварлагч багш нар болон доктор Енэрийн дэмжлэгтэйгээр дараахь сэдвээр бэлдсэн 12 модульд орсон ойлголт, кэйс жишээг судалж ярилцлаа:

- Модуль 1: Удиртгал: Компани болон компанийн засаглал
- Модуль 2: Монгол улсын болон олон улсын компанийн засаглалын орчин
- Модуль 3: ТУЗ
- Модуль 4: Хувьцаа эзэмшигчид болон хувьцаа эзэмшигчийн идэвхтэй оролцоо
- Модуль 5: Гүйцэтгэх болон гүйцэтгэх бус захирлуудын цалин, урамшуулал
- Модуль 6: Санхүүгийн хяналт, аудит, ил тод мэдээлэх
- Модуль 7: Компани нийлэх: нэгдэх ба шинээр эзэмших
- Модуль 8: Эрсдэлийн удирдлага
- Модуль 9: Компанийн засаглал дахь санхүүгийн байгууллагуудын үүрэг роль
- Модуль 10: Компанийн нийгмийн хариуцлага
- Модуль 11: ТУЗ-ийн хороод, хурал зохион байгуулах
- Модуль 12: Ногдол ашиг, хөрөнгө оруулалт, санхүүгийн бодлого, стратеги

Өдөр бүрийн сургалтын төгсгөлд оролцогчид үнэлгээний маягт бэглэсэн. Эдгээрийг нэгтгэсэн үр дүнгээс үзэхэд сургалт семинарт оролцогчдын дийлэнх нь компанийн засаглалын энэхүү семинарыг эергээр дүгнэж цаашид уг сургалтыг бусад компаниудад явуулахыг зөвлөмж болгосон байлаа.

## Замын-Үүдийн Мэргэжлийн хяналтын албаны ажилтнууд ИТ-ийн сургалтанд хамрагдлаа

МХЕГ, ЭЗБШӨЧ төслийн хооронд 2009 оны 2 дугаар сарын 20-ны өдөр гарын үсэг зурсан ХОСБ-ийн дагуу Замын-Үүдийн

ХМХА (Хилийн Мэргэжлийн Хяналтын Алба)-ны дотоод сүлжээг (ДС) байгуулахад туслалцаа үзүүлэх зорилгоор энэ 3 дугаар сарын 16-20-ны өдрүүдэд хоёр байгууллагын мэргэжилтнүүд Замын-Үүдэд ажиллалаа. ЭЗБШӨЧ төслийн санхүүжилтээр зохион байгуулсан Мэдээллийн Технологи (МТ)-ийн хоёр өдрийн практик сургалтад Замын-Үүдийн ХМХА-ны 53 байцаагчид хамрагдав. Уг сургалт нь Замын-Үүдийн МХА-нд дотоод сүлжээ суурилуулах, түүний аюулгүй байдлыг хангахад голлон чиглэгдсэн юм.



Дээрх сургалтын гол сэдвүүдэд дараахь орсон. Үүнд:

- Сүлжээний бодлого, стандартууд
- Энгийн болон сервер компьютерийн анхан шатны хамгаалалтын тохиргоо

- Компьютерийн найдвартай, аюулгүй хэрэглээний үндсэн зарчмууд
- Оффисын хэрэглээний программуудыг нөөцлөн авах, сэргээх
- Компьютерийн тоног төхөөрөмжийн байнгын арчилгаа, засвар үйлчилгээ
- Компьютерийг үр өгөөжтэй ашиглах шилдэг туршлага
- Интернет, и-мэйл, харилцаа холбооны системүүд.

Үүнээс гадна дөрвөн байцаагчийг компьютерийн системийн арчилгаа, засвар үйлчилгээ, үйлдлийн системийг суулгах, вирусын эсрэг хамгаалалтын тохиргоо, сүлжээний админы өдөр тутмын ажлуудыг багтаасан ахисан түвшний сургалтанд хамруулж сургалаа.

Замын-Үүдийн ХМХА-нд дотоод сүлжээ суурилуулж байгаа нь уг албаны өдөр тутмын ажлын үр ашгийг дээшлүүлэх, түүнийг Гаалийн мэдээллийн ГАМАС системтэй холбох бэлтгэл ажлыг хангахад оршиж байна.

Энэхүү цуврал нь ЭЗБШӨЧ төслийн үйл ажиллагааны сар тутмын цахим хэвлэл юм. Та өөрийн санал бодол болон манай цувралыг захиалах буюу захиалгаа цуцлах хүсэлтээ ЭЗБШӨЧ төслийн цуврал хариуцсан эрхлэгчид дараахь хаягаар ирүүлнэ үү.  
И-мэйл [fbertoli@eprc-chemonics.biz](mailto:fbertoli@eprc-chemonics.biz), факс: (976-11) 32 78 25.